

Ерөнхий боловсролын салбарын бодлогын зохицуулалт, сургалтын байгууллагын хөгжил, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Аръяа Цолмон
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ерөнхий боловсролын салбарын богино, дунд хугацааны арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх							
1	Ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициент, нэг ээлжээр хичээллэх сургуулийн боломжийг судалж, санал боловсруулна.	Хичээлийн байр, анги танхимын хүчин чадал ашиглалтын үнэлгээний үр дүн, санал	ЕБС-ийн ачааллыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2023 оны 234 дүгээр тогтоол	-	Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн коэффициентыг 2023-2024 оны хичээлийн жилийн статистикийн мэдээлэлд үндэслэн (i) анги танхим ашиглалт, (ii) барилгын хүчин чадал ашиглалт гэсэн хоёр аргаар тооцлоо. Эдгээр үнэлгээний дүнг нэгтгэн нэгдсэн үнэлгээг тооцож гаргасан бөгөөд <1.1-ээс тохиолдолд “нэг ээлж”, 1.1-2.0 бол “хоёр ээлж”, 2.1-2.4 бол “судлах шаардлагатай”, 2.4-өөс дээш байгаа бол “яаралтай арга хэмжээ авах” гэсэн үзүүлэлтээр авч үзсэн. Тооцооллоор төрийн болон орон нутгийн өмчийн 695 сургуулийн 50.2 хувь буюу 349 (нийслэлд 35 сургууль) нь нэг ээлж, 46.3 хувь буюу 322 (нийслэлд 114) нь хоёр ээлжээр тус тус хичээллэх	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					боломжтой бол 3.5 хувь нь нормативаас өндөр байна. Өөрөөр хэлбэл, ээлжийн ачаалал 2.48-3.68 буюу “яаралтай” ангилалд 9 (нийслэлд 6), 2.12-2.59 буюу “судлах шаардлага” ангилалд 15 (нийслэл 8) сургууль, нийт 24 сургууль нормативаас өндөр гэсэн үг. Харин ээлжийн ачааллын үзүүлэлт 1.1-ээс бага боловч хоёр ээлжээр хичээллэж байгаа 147 (нийслэлд 18) сургууль байна. Хавсралт: 1 файл		
2	Ерөнхий боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын төсөл боловсруулж батлуулна.	Хичээлийн жилийн зорилго, зорилт	Ерөнхий боловсролын салбарт хэрэгжүүлэх бодлогын шинэчлэлийн зорилт батлагдсан	Шинэ хичээлийн жилийн зорилго, зорилтыг батлуулсан байна.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын төслийг боловсруулж Боловсролын сайдаар батлуулав. Суралцагчийн эзэмших чадамжийг хөгжүүлэх асуудлыг хичээлийн жилийн зорилгын цөмд авч үзэж, хичээл, сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулахад тэргүүлэх ач холбогдол өгөхийг чухалчлав. Энэхүү зорилгыг 12 зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ. Зорилго, зорилт нь (i) хичээл, сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүн, (ii) сургалтын хөтөлбөр, сурах бичгийн шинэчлэлийг хэрэгжүүлэх бэлэн байдал, (iii) багшийн мэргэжлийн хөгжил, мэргэжлийн хамтын ажиллагааг дэмжих, (iv) суралцагчдад туслах, дэмжих үйлчилгээ үзүүлэх, сургалтын арга хэлбэрийг дэмжсэн суралцахуй (унших чадвар	6-р сар, 8-р сар, 9-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хөгжүүлэх, баг/сонирхлын бүлгээр төсөлт ажил гүйцэтгэх, мэргэжлийн чиг баримжаа олгох), (v) хүүхдийн өсөлт, хөгжил, эрүүл, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн болно. Хичээлийн жилийн зорилго, зорилтыг Улаанбаатар хотноо 2024 оны 08 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгуулсан аймаг, нийслэлийн боловсролын газрын удирдах ажилтан, мэргэжилтнүүдийн семинарт танилцуулав. Хавсралт: 2 файл		
3	Ерөнхий боловсролын сургуулийн нэршлийг хуульд нийцүүлэн журамлах арга хэмжээний санал, шийдвэрийн төсөл боловсруулна.	БШУ-ны сайдын тушаал	Ерөнхий боловсролын сургуулийн нэршлийн загвар /Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/244 дүгээр тушаал/	-	Ерөнхий боловсролын сургуулийн нэршлийг Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн нэр томъёонд нийцүүлэх зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн нэршлийн загвар”-ыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/28 дугаар тушаалаар баталлаа. Энэ тушаалаар (i) сургуулийн нэрийг улсын хэмжээнд нэгдсэн загварын дагуу бичихээр зохицуулж, бичвэрийг тушаалын хавсралтаар баталсан, (ii) их, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын сургуулиас бусад ерөнхий боловсролын сургуулийн нэрийн өмнө “харьяа/түшиц” гэсэн бичвэр хэрэглэхгүй байх, (iii) шинээр байгуулах орон нутгийн өмчийн сургалтын байгууллагыг оноосон нэрээр нэрлэх бодлого баримтлах, (iv) сургуулийн бүтэц, олон улсын хөтөлбөр, төрөлжсөн сургалтын нэр,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					төрийн одонгоор шагнагдсан болон гавьяат үйлстний нэрэмжит гэх зэрэг тодотголыг хэрэглэхгүй байх, (v) ерөнхий боловсролын сургуулийг шагнасан төрийн дээд одон болон гавьяат үйлстний нэрэмжит болгосон шийдвэрийг тусгайлсан самбарт байршуулж байх зэрэг асуудлыг зохицуулсан. Тушаалын хэрэгжилтийг хангах зөвлөмж боловсруулж, аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт Боловсрол, шинжлэх ухааны яамны газрын даргын 2024 оны 3/352 дугаар албан бичгээр хүргүүллээ. Хавсралт: 1 файл		
4	Хичээлийн шинэ жилийн бэлтгэл болон ерөнхий боловсролын зарим асуудлаар авах арга хэмжээний санал, шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Засгийн газрын хуралдааны шийдвэр	-	Ерөнхий боловсролын зарим асуудлаар Засгийн газрын хуралдаанд танилцуулга хийхэд Боловсролын сайдад дэмжлэг үзүүлсэн байна.	Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28, 08 дугаар сарын 21, 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанд “ЕБС-ийн суралцагчдын гуравдугаар улирлын хичээл, сургалтын үйл ажиллагаанд зарим зохицуулалт хийх”, “Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын 2024-2025 оны хичээлийн жилийн сургалт, үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажил, цаашид авах арга хэмжээний тухай” болон “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын зарим асуудлын талаар” боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хийх танилцуулга, шийдвэрийн төслийг тус тус боловсруулж, хуралдаанаар хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлэв. Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан	2-р сар, 8-р сар, 9-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаас 8 дугаар тэмдэглэл, 08 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаас 28, 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаас 33 дугаар тэмдэглэл тус тус гарсан болно. Хавсралт: 3 файл		
1.2. Ерөнхий боловсролын салбарын нийтлэг харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлага, зохицуулалтаар хангах							
5	Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуультай байгуулах гэрээний үр дүнгийн шалгуур боловсруулна.	Үр дүнгийн шалгуур	-	-	“Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд улсын төсвөөс хувьсах зардлын санхүүжилт олгох гэрээний үр дүнгийн шалгуур”-ыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 64 дүгээр тушаалаар батлууллаа. Энэ тушаалаар харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэх удирдлагатай аймаг, нийслэлийн боловсролын газар жил бүр гэрээ байгуулж, үр дүнд суурилан санхүүжилт олгох, гэрээний гүйцэтгэлийг санхүүгийн жилд хоёр удаа үнэлэхээр тус тус зохицуулсан. Харин үр дүнгийн шалгуур нь үндэсний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчдын монгол хэл, бичиг, унших чадварын түвшин, тэгш хамруулан сургах боловсролыг дэмжих, суралцагчийн сурч боловсрох эрхийг хангах 4 багц асуудлын гүйцэтгэлийг хэмжихэд чиглэсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Хавсралт: 1 файл		
6	Цэцэрлэг, сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам боловсруулна.	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаал	-	-	“Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/158 дугаар тушаалаар батлагдаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 6784 дугаарт бүртгэгдсэн. Журамд (i) Зөвлөл нь орон тооны бус байх, зөвлөл холбогдох хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, (ii) зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байх, хурлаар Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 23.2, 24.5-д заасан чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэх, хурлын бэлтгэл ажил, хурлын тэмдэглэлд тусгах асуудал, хурлын шийдвэр нь санал, дүгнэлт, зөвлөмж /тогтоол/ хэлбэртэй байх, (iii) зөвлөл үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллах, зөвлөлийн хурлын шийдвэр болон төлөвлөгөөний хэрэгжилтийг зөвлөлийн хурлаар хэлэлцэх, (iv) хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх зорилгоор гишүүдийг багийн зохион байгуулалтаар ажиллуулах, тодорхой асуудлаар үйл ажиллагаандаа туслах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулж болох, (v) Зөвлөлийн бүрэлдэхүүн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой	4-р сар, 5-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					асуудлаар цэцэрлэг, сургуулийн гүйцэтгэх удирдлагатай бичгээр харилцах, тэдний албан үүрэгт хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, эсхүл багш, ажилтны хувийн эрх, нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдах аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахыг хориглох, (vi) зөвлөлийн хурлын шийдвэр болон бусад мэдээлэл, тайланг талуудад ойлгомжтой байдлаар мэдээлэх. Зөвлөлийн гишүүдэд Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 24.6-д заасан дэмжлэгийн хүрээнд урамшуулал олгож болох зэрэг асуудлыг тусгалаа. Мөн энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үүсгэн байгуулагчийн төлөөллийг хангах, Зөвлөлийн бүрэлдэхүүн сонгох, зөвлөлийг дундын хэлбэрээр байгуулах асуудлаар “ЗӨВЛӨМЖ” боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны 2/1800 дугаар албан бичгээр Боловсролын ерөнхий газар, аймаг, нийслэлийн боловсролын газарт хүргүүлэв. Хавсралт: 1 файл		
7	Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтан мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр	Багшид мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмын хэрэгжилтэд үнэлгээ	Журам захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн байна.	"Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмын төсөл"-ийг хууль тогтоомжид нийцүүлэн дахин сайжруулсан бөгөөд журам Боловсролын сайдын 2024 оны А/95 дугаар тушаалын хоёрдугаар	9-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн

	боловсруулна.		хийгдсэн		хавсралтаар батлагдаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6947 дугаарт 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр бүртгэгдсэн. Энэхүү журмыг хэрэгжүүлэх зөвлөмжийг холбогдох албан хаагчийн хамт боловсруулан аймаг, нийслэлийн боловсролын газарт 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр (12/1982 дугаар албан бичиг) хүргүүллээ. Хавсралт: 3 файл		даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
8	Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм боловсруулна.	Журам захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн байна.	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/100 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм” батлагдаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2024 оны 3 дугаар сарын 22-ний өдрийн 6745 дугаарт бүртгэгдсэн. Энэхүү дүрмээр (i) сургууль хуулийн этгээд болохыг тодорхойлж, суралцагч бүрд тэгш хүртээмжтэй, тэгш боломж олгосон чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх, (ii) суралцагчийн ялгаатай байдал, хувийн онцлог, хэрэгцээг хүндэтгэн авьяас, чадвар, сонирхлыг хөгжүүлэх, тэдэнд туслах, дэмжих үйлчилгээ үзүүлэх, (iii) сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчил, үе тэнгийн дээрэлхэл, дарамт, ялгаварлан гадуурхалт, гэмт хэрэг, хорт зуршил, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлэх, (iv) боловсролын харилцаанд оролцогч талуудын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх шийдвэр гаргахын өмнө тэдний саналыг заавал авч, хэлэлцэх, баталгаажсан шийдвэрийг мэдээлж байх, мөн сургуулийн хэмжээнд мөрдөх зарим дүрэм, журмын төсөл боловсруулахад тэд оролцох, дагаж мөрддөг байх, (v) багш нарын зөвлөл, мэргэжлийн багш нарын бүлгийн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг болон сургуулийн үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоог тус тус тодорхойлж, (vi) холбогдох хуулиар зөвшөөрсөн төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах зэрэг асуудлыг зохицуулсан. Хавсралт: 1 файл		
9	Ерөнхий боловсролын зарим сургуулийн удирдах зөвлөл дэх үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэх санал, шийдвэрийн төсөл боловсруулна.	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр	-	Үүсгэн байгуулагчийн төлөөллийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр батлуулсан байна.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн хууль, Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/158 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-д тус тус нийцүүлэн олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчийн ерөнхий боловсролын “Шинэ эрин”, “Шинэ эхлэл”, “Монгол тэмүүлэл” сургууль болон Монгол-Оросын хамтарсан ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн	9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					удирдах зөвлөл дэх үүсгэн байгуулагчийн төлөөллийг Боловсролын сайдын 2024 оны А/96, А/200 дугаар тушаалаар тус тус шинэчлэн баталлаа. Үүсгэн байгуулагчийн төлөөлөл олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд 6, Монгол-Оросын хамтарсан ерөнхий боловсролын 3 дугаар сургуульд 7 байхаар зохицуулсан. Хавсралт: 2 файл		
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
10	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд	Хууль тогтоомж, шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан	Хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийн 2023 оны тайлан	Хууль тогтоомж, шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг холбогдох заавар, аргачлалын дагуу тогтоосон хугацаанд чанартай тайлагнасан байна.	Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар баталсан аргачлалыг тус тус баримтлан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулан хэрэгжилтийг 6, 12 дугаар сард тус тус тайлагнан ажиллалаа.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

	хүргүүлэх						
11	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Албан бичгийн шийдвэрлэлт болон гомдол барагдуулалтын хувь, Байгууллагын архивт өгсөн хадгаламжийн нэгж/тоо/	-	Өргөдөл, гомдлыг хугацаанд нь, чанартай, бүрэн гүйцэд шийдвэрлэсэн байна. Байгууллагын архивт баримт бичиг, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд өгсөн байна.	Тайлангийн хугацаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу эрхлэх асуудлаар 1 боть/228 хуудас бүхий/ материалыг хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивд 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр хүлээлгэн өгсөн. Мөн иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 26 өргөдөл, гомдол, 35 албан бичиг (2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар) хуулийн хугацаанд бүрэн барагдуулсны гадна нийт 40 албан бичгийн төсөл боловсруулж, холбогдох удирдах ажилтнаар хянуулан баталгаажуулан хүргүүлсэн байна. Харин Авлигын эсрэг хуулийн 10.3-т заасны дагуу "2023 оны хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийг 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр https://meduuleg.iaac.mn/AOS/Login цахим системээр илгээж, баталгаажуулсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг судлах	Шинээр батлагдсан хууль, Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тушаалыг тухай бүр судалж, захиргааны хэм хэмжээний акт боловсруулахад хууль тогтоомжийг зөв хэрэглэх, хууль хоорондын уялдаа холбоог хангах	Эрхлэх асуудалд хамаарах хууль тогтоомж, шийдвэрийн бүртгэл үүсгэсэн	Шинээр батлагдсан хууль тогтоомж, шийдвэрийг уншиж судалсан байна.	Монгол Улсын Их Хурлаас 2024 онд батлагдаж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршсан эрхлэх асуудалд хамаарах 11 хууль (Хүүхэд хамгааллын тухай, Биеийн тамир, спортын тухай, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай, Үндэсний баялгийн сангийн тухай зэрэг), 2 тогтоол (УИХ-ын 2024 оны 64, 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр)-ыг тус тус уншиж судаллаа.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					Мөн Засгийн газрын 2024 оны 02, 25, 39, 72, 82, 104, 141, 178, 192, 53, 73, 91, 96, 109 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”, “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүн”, “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”, “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”, “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036)”, “Багшийн гурван тулгуурт бодлого” цогц арга хэмжээ”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан	
--	--	--	--	--	---	--

					тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” зэрэг захиргааны хэм хэмжээний 14 актыг тус тус судлан эрхлэх асуудлаар бодлогын баримт бичиг боловсруулахад ашиглаж байна.		
2	Ерөнхий боловсролын салбарын чиглэлээр гарч байгаа олон улсын судалгааны ажил, өгүүллэг уншиж гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх	UNESCO, OECD зэрэг олон улсын байгууллагын цахим сайтаас боловсролын хөгжлийн чиг хандлагын талаар гарч байгаа бодлогын зөвлөмж, гарын авлагыг уншиж судлах	Англи хэлээр унших, бичих, ойлгох дунд түвшний чадвартай	Боловсролын хөгжлийн олон улсын чиг хандлагыг судалж бодлого боловсруулахад ашиглана	Тайлангийн хугацаанд ЮНЕСКО, Дэлхийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага/OECD/ байгууллагын цахим хуудаснаа байршсан "Recommendations UN Secretary-General's High-Level Panel on the Teaching profession", "Global report, Teachers addressing teacher shortages and transforming profession (2024), "AI revolution in education, what you need to know", "Education at Glance 2024", "Global Education Monitoring Report 2024/25" зэрэг 10 гаруй судалгааны тайлан, өгүүлэл, сургалтын материалтай тус тус танилцан, англи хэлний чадвараа сайжруулж, мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлэв	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ерөнхий боловсролын салбарын бодлогын зохицуулалт, сургалтын байгууллагын хөгжил, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Аръяа
Цолмон /...../ Огноо: